

ТАНИЛЦУУЛГА

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх”-ээр заасан бөгөөд энэ хүрээнд бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгож, татварын орчныг сайжруулах, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэрэг зорилтуудыг тусгасан.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх, идэвхжүүлэх үйл ажиллагааг дэмжих шаардлага тулгарч буйг харгалзан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан.

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр баталсан. Тус зохицуулалтаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсгийг нэмэлтээр оруулсан бөгөөд 15 дугаар зүйлийн 15.6, 15.9-д заасан зохицуулалт нь агуулгын хувьд давхцаж байсан тул нэгтгэн томьёолж, тус заалтуудыг хүчингүй болгосон.

Ийнхүү Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6, 15.9 дэх хэсэг буюу хүчингүй болсон хэсгүүдийг ишилсэн байсан тул Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оныдугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

**МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсгийн “, 15.1.6, 15.1.9” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг